

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1. Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн хүний нөөцийн бодлого нь Монгол Улсын хууль тогтоомж, төрийн бодлого, Ус цаг байгууллагад алба хаах журамд үндэслэсэн хүний нөөцийн талаар баримтлах залгамж чанартай үндсэн баримт бичиг мөн.

1.2. Энэхүү бодлогын баримт бичиг нь УЦУОШТ-ийн хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах замаар гүйцэтгэлд суурилсан бүтээлч, чадварлаг, тогтвор суурьшилтай хүний нөөцийг бий болгож байгууллагын тогтвортой хөгжлийг хангахад чиглэнэ.

Хоёр.Хүний нөөцийн бодлогын зорилго,баримтлах зарчим, үндсэн чиглэл

2.1. УЦУОШТ-ийн хүний нөөцийн бодлогын зорилго

Байгууллагын зорилт, чиг үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хэрэгжүүлэх чадавхтай хүний нөөцийг бүрдүүлэх, сургаж хөгжүүлэх, идэвхжүүлэх, хүний нөөцийн манлайлалыг хангах, мэдээллийн системийг сайжруулах замаар хүний нөөцийн удирдлагын үйл ажиллагааг сайжруулахад оршино.

2.2. Хүний нөөцийн бодлогын зарчим

- 2.2.1. Шударга ёс, ил тод, тэгш байдал
- 2.2.2. Мерит тогтолцоо, мэргэшсэн тогтвортой байдал
- 2.2.3. Сурч хөгжих боломж
- 2.2.4. 2.4. Хараат бус бие даасан байдал
- 2.2.5. Гүйцэтгэлд суурилсан урамшуулал

2.3. Хүний нөөцийн бодлогын үндсэн чиглэл

2.3.1. Ажлын байрны хэрэгцээ, шаардлагад нийцсэн чадварлаг, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх:

- 2.3.2. Хүний нөөцийн хөгжлийг хангаж, чадавхийг бэхжүүлэх;
- 2.3.3. Албан хаагчдын нийгмийн баталгаа, ажлын байрны орчинг сайжруулах;
- 2.3.4. Удирдлагын манлайллыг хангаж, карьер хөгжлийн тогтолцоог бүрдүүлэх;
- 2.3.5. Хүний нөөцийн мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлж ашиглах.

Гурав.Хүний нөөцийн бодлого